



**ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛСОН  
ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙГ  
БИЕЛҮҮЛЭХ ТУХАЙ**

**ЛАВЛАГАА**

**Шүүхийн ерөнхий  
зөвлөлийн даргын  
захиалгаар бэлтгэв.**

## ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛСОН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙГ БИЕЛҮҮЛЭХ ТУХАЙ /ЛАВЛАГАА/

1. Эрх зүйн зохицуулалт
2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа
  - А. Иргэний хэргийн талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа
  - Б. Эрүүгийн хэргийн талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа
  - В. Захиргааны хэргийн талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа
  - Г. Зөрчлийн хэргийн талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа
3. Шүүхийн шийдвэрийг гүйцэтгэж буй байдал
  - А. Шүүхийн шийдвэрийг гүйцэтгүүлэх ажиллагаа
  - Б. Шүүхийн шийдвэрийг биелэлт
4. “Шүүхийн шийдвэрийг үл биелүүлэх” үйлдэл зөрчил эсхүл гэмт хэрэг болох нь
  - А. Зөрчлийн шинж
  - Б. Гэмт хэргийн шинж
5. Дүгнэлт

### Оршил

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх хэсэгт иргэн эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх эрхтэй, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт: “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц...хууль зүйн...баталгааг бүрдүүлэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж заасны дагуу иргэдийн хөндөгдсөн эрх, ашиг сонирхлыг хамгаалахын тулд иргэний болон эрүүгийн, захиргааны, зөрчлийн хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэрийг зайлшгүй биелүүлэх зарчимтай. Мөн Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд түүнийг бүх шүүх, бусад этгээд заавал биелүүлнэ.” гэж заасан бөгөөд зөвхөн Улсын дээд шүүх бус бүх шатны шүүхийн хүчин төгөлдөр болсон шийдвэрийг заавал биелүүлэх зарчмыг тодотгожээ.

Хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаа нь аливаа хэрэг хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны үргэлжлэл бөгөөд төгсгөлийн шат юм.<sup>1</sup> Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зорилго нь шүүхээс гарсан шийдвэрийг албадан биелүүлж, бусдын хуулиар хамгаалагдсан эрх ашгийг бодит байдлаар сэргээхэд оршдог.

Шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх үндэслэл нь хуулийн хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэр, магадлал, тогтоол, шүүгчийн захирамж, шийтгэвэр зэрэг байна.

---

<sup>1</sup> Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллага “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг боловсронгуй болгох-чадавхийг бэхжүүлэх” төсөл. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа гарын авлага. УБ.,2016 он. 51 дэх тал.



Монгол Улсын шүүхийн тухай хуульд эрүү, иргэн, захиргааны хэргийн анхан, давах, хяналтын шатны шүүхээс гаргасан шүүхийн шийдвэрийг заавал биелүүлэх, хэрэв биелүүлээгүй тохиолдолд албадан гүйцэтгэх тухай заасан байдаг.<sup>2</sup>

Гэсэн хэдий ч шүүхийн шийдвэрийг биелүүлэх ажиллагаа хангалтгүй байгаа, шүүхийн шийдвэр биелэгдэхгүй зэрэг асуудал байгаа тул энэхүү лавлагаагаар хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэрийг биелүүлэх Монгол Улсын эрх зүйн зохицуулалт, эрүү, иргэн, захиргаа, зөчлийн хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, шүүхийн шийдвэрийг гүйцэтгэж буй байдал, түүний биелэлт, “Шүүхийн шийдвэрийг үл биелүүлэх” үйлдэл зөрчил эсхүл гэмт хэрэг болох эсэх хүрээнд дүн шинжилгээ хийж, шинжлэн судлав.

## **1. Эрх зүйн зохицуулалт**

Шүүхийн шийдвэрийг биелүүлэх, биелүүлээгүй тохиолдолд албадан гүйцэтгэх тухай зохицуулалт нь эрүү, иргэн, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх талаар салбар процессын хуульд хэрхэн зохицуулсан байдаг талаар авч үзье. Үүнд, шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд зааснаар /6.1 зүйл/ шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг иргэний хэргийн талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, эрүүгийн хэргийн талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, зөрчлийн хэргийн талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, захиргааны хэргийн талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа гэж дөрөв ангилан авч үзэх нь тохиромжтой байна.

<b>Шүүхийн тухай хууль /32 дугаар зүйл/</b>	<b>Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль</b>	<b>Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль</b>	<b>Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль</b>	<b>Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль</b>
<b>/32.1/ Шүүхийн шийдвэрийг заавал биелүүлэх үүрэгтэй.</b>	11 дүгээр зүйл. Шүүхийн шийдвэр заавал биелэгдэх.	37.3 дугаар зүйл. Шүүхийн шийдвэрийг биелүүлэх.	12 дугаар зүйл. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг заавал биелүүлэх.	9.3 дугаар зүйл. Шүүгчийн шийтгэл оногдуулсан шийдвэрийг биелүүлэх.
<b>/32.2/ Шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй бол албадан гүйцэтгэнэ.</b>	11 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг.	37.2 дугаар зүйл. Шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх.	12 дугаар зүйл. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг заавал биелүүлэх.	9.3 дугаар зүйл. Шүүгчийн шийтгэл оногдуулсан шийдвэрийг биелүүлэх.
<b>/32.3/ Шүүхийн шийдвэрийг санаатай биелүүлээгүй бол хариуцлага хүлээлгэнэ.</b>	<ul style="list-style-type: none"> <li>Зөрчлийн тухай хууль 15.27 дугаар зүйл. “Шүүхийн шийдвэрийг үл биелүүлэх”</li> <li>Эрүүгийн хууль 21.7 дугаар зүйл. “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд саад учруулах, зайлсхийх”</li> </ul>			

<sup>2</sup> Шүүхийн тухай хууль 32 дугаар зүйл. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх. “32.1.Шүүхийн шийдвэрийг Монгол Улсын нутаг дэвсгэрт оршин суугаа хувь хүн, үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээд заавал биелүүлэх үүрэгтэй.”, “32.2.Шүүхийн шийдвэрийг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр биелүүлээгүй бол хуульд заасан үндэслэл, журмын дагуу албадан гүйцэтгэнэ.”, “32.3.Хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг санаатай биелүүлээгүй, эсхүл биелүүлэхэд нь зориуд саад учруулсан этгээдэд хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.”



Дээрх хүснэгтэд харуулсан эрх зүйн зохицуулалтаас харвал Шүүхийн тухай хуульд зааснаар,

- 1) **Шүүхийн шийдвэрийг хувь хүн, хуулийн этгээд заавал биелүүлэх үүргийн** талаар иргэний, эрүүгийн, захиргааны, зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх хуулийн зохицуулалтад тусгайлан заасан байна.
- 2) **Шүүхийн шийдвэрийг заавал биелүүлэх үүргээ биелүүлээгүй тохиолдолд тухайн шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэх** талаар мөн салбар хуульд тусгайлан заасан байна. Энэ тохиолдолд хэргийн оролцогч шүүхийн журмаар албадан гүйцэтгүүлэхээр хуульд заасны дагуу<sup>3</sup> шүүхэд хандан, шүүх албадан гүйцэтгүүлэх эсэх тухай асуудлыг шийдвэрлэхээр зохицуулсан байна.
- 3) **Шүүхийн шийдвэрийг санаатайгаар биелүүлээгүй, биелүүлэхэд нь саад учруулсан** тохиолдолд хууль зүйн хариуцлага хүлээлгэхээр Шүүхийн тухай хуульд заасан байх ба Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуульд “шүүхийн шийдвэрийг тодорхой тохиолдолд биелүүлээгүй” тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг тусгайлан заасан байна.

## **2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа**

### *А. Иргэний хэргийн талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа*

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-т “Шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийг иргэн, хуулийн этгээд заавал биелүүлнэ”, 11.2-т “Шүүхийн шийдвэрийг сайн дураар биелүүлээгүй бол хуульд заасан үндэслэл, журмын дагуу албадан гүйцэтгэнэ.” гэж заасан байна. Салбар эрх зүйн хэм хэмжээ буюу Шүүхийн тухай хуулийн 32 дугаар зүйлд заасан “шүүхийн шийдвэр гүйцэтгэх” хуулийн зүйл заалтыг баталгаажуулан зохицуулсан байна.

Иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь шийдвэр гүйцэтгэгч, төлбөр авагч, төлбөр төлөгчийн хооронд төлбөрийг биелүүлэхтэй холбоотой эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдсан харилцааны нийлбэр байна. Уг ажиллагаанд оролцох субъектийн хувьд нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээд, өмгөөлөгч, төлөөлөгчийн хооронд үүсэж болох харилцаа байдаг.

Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг иргэний хэргийн болон эрүүгийн хэргийн хамт шийдвэрлэсэн иргэний нэхэмжлэлийн талаарх шүүхийн шийдвэр, хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн шүүгчийн захирамж, шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ авах тухай шүүгчийн захирамж зэрэг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 6.2 дугаар зүйлд заасныг үндэслэн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулна.

Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа үүсгэх, нэгтгэх, түдгэлзүүлэх, дуусгавар болгох зэрэг ажиллагааны тухай зохицуулалтыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн хоёрдугаар хэсэгт тодорхой заасан байна.

Иргэний хэргийн талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгөөс төлбөр гаргуулах ажиллагаа байх ба уг ажиллагаанд

<sup>3</sup> Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. Төрийн мэдээлэл 2017 он №24/981/



төлбөр төлөгчийн бие, эд зүйлд үзлэг, нэгжлэг хийх, битүүмжлэх, барьцаалах, хураах, худалдан борлуулах зэрэг шийдвэр гүйцэтгэлийн нийтлэг ажиллагаануудыг хийж гүйцэтгэдэг.

#### *Б. Эрүүгийн хэргийн талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа*

Эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь гэм буруу нь шүүхээр тогтоогдсон этгээдэд оногдуулсан ялыг эдлүүлж нийгэм, иргэдийн эрх ашиг сонирхлыг хамгаалах явдал байдаг.

Монгол Улсын Шүүхийн тухай хуульд зааснаар шүүхийн шийдвэрийг хувь хүн, хуулийн этгээд заавал биелүүлэх үүрэгтэй ба энэхүү үүргээ биелүүлээгүй тохиолдолд шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэж, хариуцлага оногдуулах талаар заасан. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд мөн энэхүү агуулга бүхий зохицуулалтыг оруулсан байна. Үүнд, хуулийн 37.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийг аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, хүн, хуулийн этгээд биелүүлнэ.”, мөн 37.2 дугаар зүйлд “1.Энэ хуульд заасан хугацаанд давж заалдах гомдол, эсэргүүцэл гаргаагүй бол уг хугацаа дуусмагц шүүхийн шийдвэрийг гүйцэтгэнэ.” гэж заасан байна.

Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуульд гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулах ялын төрөл өөрчлөгдсөнтэй уялдаж шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа мөн өөрчлөгдсөн. Тухайлбал, нийтэд тустай ажил хийлгэх ял, зорчих эрхийг хязгаарлах ял, эрх хасах ял зэрэг шинэ төрлийн ялын төрлийг оногдуулсан шүүхийн шийдвэрийг хэрхэн гүйцэтгэх талаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн дөрөвдүгээр хэсэгт шинэчлэн зохицуулсан.

#### *В. Захиргааны хэргийн талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа*

Захиргааны хэргийн шүүхийн зорилго бол иргэн, хуулийн этгээдийн эрхийг хамгаалахад чиглэдэг тул шийдвэр гүйцэтгэл нь мөн энэ зорилгыг хангахад оршдог. Тиймээс ч Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа холбогдох захиргааны байгууллага, хуулийн этгээд, албан тушаалтан, хүн заавал биелүүлэх үүрэгтэй бөгөөд сайн дураар биелүүлээгүй бол хуульд заасан үндэслэл, журмын дагуу албадан гүйцэтгэнэ.” гэж заасан.

Захиргааны шийдвэр гүйцэтгэлийн хувьд нэг талд захирамжилсан шийдвэр гаргах эрхтэй захиргааны байгууллага, албан тушаалтан, нөгөө талд эрх нь зөрчигдсөн иргэн, хуулийн этгээд байдаг. Захиргааны шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь шийдвэрийг төлөөлүүлэн гүйцэтгэж болох эсвэл хариуцагч этгээд зөвхөн өөрөө гүйцэтгэх шаардлагатай онцлог<sup>4</sup> зохицуулалттай. Угтаа захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн гүйцэтгэлийн асуудал нь нийтийн эрх ашгийг хамгаалж байдаг.

Захиргааны шийдвэр гүйцэтгэх ажиллагааг захиргааны хэрэг хянан шийдвэрлэх явцад гарсан шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх, хуулийн хүчин төгөлдөр захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх, эвлэрлийн гэрээг баталгаажуулсан захирамж болон шүүгчийн шийтгэврийг гүйцэтгэх гэж ангилж болно.

<sup>4</sup> Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллага “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг боловсронгуй болгох-чадавхийг бэхжүүлэх” төсөл. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа гарын авлага. УБ.,2016 он. 59 дэх тал.



### *Г. Зөрчлийн хэргийн талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа*

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль<sup>5</sup> болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд<sup>6</sup> зааснаар хувь хүн, хуулийн этгээд нь шийтгэл болон албадлагын арга хэмжээ оногдуулсан шүүхийн шийдвэрийг нэн даруй биелүүлэх үүрэгтэй байна.

Зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулах үндэслэл нь шүүхээс гүйцэтгэх хуудас олгосон торгох шийтгэл оногдуулсан шүүгчийн шийтгэх хуудас, зөрчил үйлдэж олсон хөрөнгө, орлого, зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, тээврийн хэрэгсэл, уналгыг хураах, эсхүл түүний үнийг гаргуулан хураан авах тухай шийдвэр, хохирол нөхөн төлбөр гаргуулах тухай шийдвэр, албадан эмчилгээ, албадан сургалтад хамруулах тухай шүүхийн шийдвэр, баривчлах шийтгэл оногдуулсан шүүхийн шийдвэр зэрэг байна. /Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль 139 дүгээр зүйлийн 139.1 дэх хэсэг/ Торгох болон баривчлах шийтгэл оногдуулсан шүүхийн шийдвэрийг биелүүлэх талаар тусгайлан хуульд заасан ба эрх хасах шийтгэл оногдуулсныг биелүүлэхэд эрүүгийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаан дахь журмыг баримтална.

Дээрх байдлаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нийт дөрвөн төрлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хуульчилсан ба эдгээр нь зохицуулалтын хувьд төрөл, хэрэгжүүлэх ажиллагаа, хэлбэрийн хувьд ялгаатай байх боловч аль шүүхээс гаргасан шийдвэр /аль ч төрлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа байсан/ эсэхээс үл хамааран тухайн шийдвэрийг хувь хүн, хуулийн этгээд биелүүлэх үүрэгтэй байхыг, үүргээ биелүүлээгүй тохиолдолд шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн байгууллагаас албадан биелүүлүүлэх тухай шүүхэд хандан, шүүх түүнийг шийдвэрлэх эрхтэй байх нийтлэг зохицуулалт үйлчилнэ. Энэ хүрээнд хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэхтэй холбоотой шүүхийн шийдвэр гүйцэтгэгчийн хууль ёсны шаардлагыг үл биелүүлсэн, шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд саад учруулсан хүн, хуулийн этгээдэд хуульд заасан хариуцлага хүлээлгэхээр заажээ.


### **3. Шүүхийн шийдвэрийг гүйцэтгэж буй байдал**

#### **А. Шүүхийн шийдвэрийг гүйцэтгүүлэх ажиллагаа**

Дээр дурьдсаны дагуу иргэн, эрүү, захиргаа болон зөрчлийн хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь процессын тухай хууль болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан журмын дагуу явагдах бөгөөд шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй тохиолдолд албадан гүйцэтгүүлэх талаарх асуудлыг хэргийн оролцогчид болон зарим тохиолдолд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанаас шүүхэд хүсэлт гарган шийдвэрлүүлнэ.

<sup>5</sup> Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль 9.3 дугаар зүйлийн 9.3.1 дэх хэсэгт “Шүүгчийн торгох шийтгэл оногдуулсан шийдвэрийг зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор сайн дураараа биелүүлэх үүрэгтэй.” гэж заасан.

<sup>6</sup> Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль 138 дугаар зүйлийн 138.1 дэх хэсэгт “ шийтгүүлсэн этгээд зөрчлийн хэргийн талаархи хуулийн хүчин төгөлдөр шийдвэрийг хууль болон шийтгэл, албадлагын арга хэмжээ оногдуулах тухай шийдвэрт өөрөөр заагаагүй тохиолдолд нэн даруй биелүүлэх үүрэгтэй.” байхаар заасан байна.



Тухайлбал, 2017 оны 3 сарын 3-ны өдөр Нийслэлийн Захиргааны хэргийн шүүхээс “Захиргааны актын биелэлтийг түр түдгэлзүүлэх тухай” шүүгчийн захирамж гарсан боловч уг захирамжийг биелүүлэлгүйгээр 3 сарын 5-ны өдөр “Дүнжингарав хурдан морьны уралдаан” зохион байгуулагдсан ба шүүхийн шийдвэрийг биелүүлэлгүй уралдааныг зохион байгуулсанд хариуцлага хүлээх эсэх талаар нэлээдгүй маргаан үүссэн. Энэ талаар Нийслэлийн Захиргааны хэргийн шүүхээс тайлбарлахдаа “шүүхийн шийдвэрийг албадан биелүүлэх хүсэлтийг нэхэмжлэгчид шүүхэд гаргаагүй. Энэ тохиолдолд шүүх өөрөө санаачлагаараа албадан гүйцэтгүүлэх боломжгүй.”<sup>7</sup> хэмээн Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн дагуу тайлбарлажээ. Нөгөө талаас шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй энэхүү үйлдэл нь цаг хугацааны хувьд Зөрчлийн тухай хууль болон шинэ Эрүүгийн хууль хэрэгжихээс өмнө болсон ба хуучин эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн шинжийг бүрэн хангаж байгаа үйлдэл боловч цагдаа, прокурор, хууль сахиулах байгууллагаас өөрийн санаачлагаар зөрчлийг таслан зогсоож хууль зүйн хариуцлага хүлээлгэх чиг үүргээ хэрэгжүүлээгүй юм.

#### Б. Шүүхийн шийдвэрийн биелэлт

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэрийн биелэлт, хэрэгжүүлэлттэй холбоотой судалгааг жил бүр хийж гүйцэтгэдэг байна. Үүнээс 2014-2016 оны хооронд шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанаас шүүхийн шийдвэрийг биелүүлсэн хувийг харьцуулан авч үзье.

<sup>7</sup> <http://ikon.mn/n/ycx>



Хүснэгт 1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны 2014-2016 оны гүйцэтгэх баримт бичгийн мэдээ.

	Иргэний хэргийн шийдвэр			Эрүүгийн хэргийн шийдвэр			Захиргааны хэргийн шийдвэр			Нийт дүн		
	Биелүүлбэл зохих	Бодитой биелүүлсэн	Биелэлтийн хувь	Биелүүлбэл зохих	Бодитой биелүүлсэн	Биелэлтийн хувь	Биелүүлбэл зохих	Бодитой биелүүлсэн	Биелэлтийн хувь	Биелүүлбэл зохих	Бодитой биелүүлсэн	Биелэлтийн хувь
2014 он	14591	9696	66.5%	3180	2994	67.6%	180	120	66.7%	29681	14816	49.9%
2015 он	22073	11542	52.3%	7891	4193	53.1%	804	594	73.9%	30839	16347	53%
2016 он	27872	13824	49.6%	6585	2881	43.8%	1255	972	77.5%	35908	17721	49.4%

Дээрх тоон баримтаас үзвэл жилээс жилд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд шүүхээс албадан гүйцэтгүүлэхээр ирүүлсэн эрүү, иргэн, захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн тоо тогтмол нэмэгдсэн байна. Түүнчлэн дээрх хугацаанд нийт 96428 албадан гүйцэтгүүлэх шүүхийн шийдвэрийн 48884 нь л биелэгдсэн ба жил тутам ойролцоогоор 51.7 хувь нь биелэгдэлгүй үлдсэн байна.

#### **4. “Шүүхийн шийдвэрийг үл биелүүлэх” үйлдлийн зөрчлийн болоод эрүүгийн гэмт хэргийн шинж**

Хүснэгт 2. “Шүүхийн шийдвэр үл биелүүлэх” талаар хуульд заасныг харьцуулсан байдал.

Шүүхийн шийдвэрийг үл биелүүлэх	2002 оны Эрүүгийн хууль	Зөрчлийн тухай хууль /2017 он/	Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/ 2017 он
		258.1. Шүүхийн шийдвэрийг үл биелүүлэх.  1. Хуулийн хүчин төгөлдөр болсон шүүхийн шийтгэх тогтоол, шийдвэр, магадлал, шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжийг <u>санаатай биелүүлээгүй, эсхүл биелүүлэхэд нь зориуд саад учруулсан</u> бол хөдөлмөрийн	15.27. Шүүхийн шийдвэрийг үл биелүүлэх.  1. <u>Эрх хасах ял шийтгүүлсэн этгээд</u> шүүхээс хүлээлгэсэн үүргийг зөрчсөн бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.





	<p>хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, нэг зуугаас хоёр зуун тавин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.</p>	<p><u>2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны оролцогч бус этгээд</u> төлбөр төлөгчийн хөрөнгийн талаархи мэдүүлгийг зориуд худал мэдүүлсэн бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</p>	<p><u>өөрчилсэн, дүр эсгэн биелүүлсэн, битүүмжилсэн, барьцаалсан, хураан авсан хөрөнгийг дүр мэдэн захиран зарцуулсан, дүр үзүүлсэн гэрээ байгуулсан</u> бол хоёр мянга долоон зуун нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p>
--	---	---	---

### А. Зөрчлийн шинж

Монгол улсын шүүхээс гаргасан, хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй үйлдэл, эс үйлдэхүйд Зөрчлийн болон Эрүүгийн хуульд зааснаар хууль зүйн хариуцлага хүлээлгэхээр заасан. Үүнд, Зөрчлийн тухай хуулийн 15.27 дугаар зүйлд “Эрх хасах ял шийтгүүлсэн этгээд шүүхээс хүлээлгэсэн үүргийг зөрчсөн бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”, “2.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны оролцогч бус этгээд төлбөр төлөгчийн хөрөнгийн талаархи мэдүүлгийг зориуд худал мэдүүлсэн бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”, мөн 3 дахь хэсэгт шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үед хуульд заасан байдлаар саад учруулан, шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй нийт 14 үйлдэл, эс үйлдэхүйг зөрчилд тооцон, хариуцлага хүлээлгэх тухай заасан байна.

Гэвч Зөрчлийн тухай хуулийн 15.27 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зөвхөн эрх хасах ял шийтгүүлсэн этгээд уг үүргээ биелүүлээгүй тохиолдлыг”, харин 2 болон 3 дахь хэсэгт “шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны оролцогч бус этгээд”-д хамаарах зохицуулалт байх ба шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны оролцогч, үүрэг хүлээсэн этгээд шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй тохиолдолд ямар хариуцлага оногдуулах талаар энэ хуульд зохицуулагдаагүй байна.

### Б. Эрүүгийн гэмт хэргийн шинж

Мөн Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын 21.7 дугаар зүйлд “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд саад учруулах, зайлсхийх” гэмт хэргийг тодорхойлсон ба үүнд “1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд саад учруулах зорилгоор хөрөнгийн мэдүүлгээ зориуд буруу гаргасан, эд хөрөнгөө нуун дарагдуулсан, бусдад шилжүүлсэн, үрэгдүүлсэн, оршин суух хаягаа өөрчилсөн, дүр эсгэн биелүүлсэн, битүүмжилсэн, барьцаалсан, хураан авсан хөрөнгийг дүр мэдэн захиран зарцуулсан, дүр үзүүлсэн гэрээ байгуулсан бол хоёр мянга долоон зуун нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” гэж заажээ.



Харин өмнө хэрэгжиж байсан 2002 оны Эрүүгийн хуулийн тусгай ангийн 258 дугаар зүйлийн 258.1 дэх хэсэгт “258.1.Хуулийн хүчин төгөлдөр болсон шүүхийн шийтгэх тогтоол, шийдвэр, магадлал, шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжийг санаатай биелүүлээгүй, эсхүл биелүүлэхэд нь зориуд саад учруулсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, нэг зуугаас хоёр зуун тавин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.” гэж заасан байжээ.

Дээр дурдсан 2002-2017 онд хэрэгжиж байсан Эрүүгийн хуульд заасан “шүүхийн шийдвэрийг санаатай биелүүлээгүй” гэх гэмт хэргийн шинж нь шинэчлэн найруулсан Эрүүгийн хууль болон Зөрчлийн хуульд агуулгын хувьд ороогүй байна. Өөрөөр хэлбэл шинэчлэн найруулсан Эрүүгийн хуульд шүүхийн шийдвэрийг биелүүлэхгүй байгаа санаатай үйлдэл, арга, этгээдийг тоочсон байх боловч уг зохицуулалтад хамаарахгүй арга, үйлдлээр шүүхийн шийдвэрийг биелүүлэхгүй санаатайгаар зайлсхийж байгаа тохиолдолд хэрхэн хариуцлага хүлээлгэх нь тодорхойгүй байна. Тухайлбал, Эрүүгийн хуулийн 21.7 дугаар зүйлд заасан гэмт хэрэгт зөвхөн уг хуульд заасан арга, үйлдэлд хариуцлага хүлээлгэхээр заасан ба үүнээс өөр арга, үйлдлийг ашиглан санаатайгаар шүүхийн хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэрийг гүйцэтгээгүй байгаа гэмт хэрэгт хамаарахгүй байна.

Өмнөх 2002 оны Эрүүгийн хуульд “Шүүхийн шийдвэрийг үл биелүүлэх” нь гэмт хэрэгт тооцогддог байсан ба дараах хүснэгтэд заасны дагуу энэ төрлийн гэмт хэргийг шүүхээр шийдвэрлэн, ял оногдуулсан байна.

Хүснэгт 3. Шүүхээс Эрүүгийн хууль /2002 он/-ийн тусгай ангийн 258 дугаар зүйлд зааснаар хэрэг хянан шийдвэрлэсэн байдал<sup>8</sup>

	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он
<b>Нийт шийдвэрлэсэн бүгд хэрэг</b>	1	7	8	7	2
<b>Ял шийтгүүлсэн бүгд хүн</b>	0	3	4	5	2

Тиймээс Зөрчлийн болон Эрүүгийн хуульд заагаагүй үйлдэлд хариуцлага хүлээлгэх боломжгүй учир “Шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй” зарим тохиолдолд хариуцлага хүлээлгэх хууль зүйн үндэслэл байхгүй, хариуцлага оногдуулах боломжгүй байна.

## **5. Дүгнэлт**

Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 32 дугаар зүйлд зааснаар шүүхийн шийдвэрийг хувь хүн, хуулийн этгээд сайн дураар биелүүлэх үүрэгтэй бөгөөд ийнхүү биелүүлээгүй тохиолдолд шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлнэ. Мөн

<sup>8</sup> Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн Шүүхийн эрүүгийн хэргийн статистик мэдээ. 2016 он.



санаатайгаар зайлсхийсэн, шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй тохиолдолд холбогдох хууль тогтоомжид зааснаар хариуцлага хүлээлгэхээр заасан байна. Энэ заалтын дагуу иргэн, эрүү, захиргаа болон зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд дээрх агуулга бүхий заалт салбар хуульд тусгалаа олсон. Мөн шүүхийн шийдвэрийг албадан биелүүлэх талаар хэргийн оролцогчид шүүхэд хандан, шүүх л зөвхөн шүүхийн шийдвэрийг албадан биелүүлэх талаар шийдвэрлэх эрхтэй байхаар зохицуулсан тул шүүхээс уг шийдвэрийг албадан биелүүлэх талаар шийдээгүй тохиолдолд тухайн шийдвэрийг албадан биелүүлэх боломжгүй юм.

Хуульд заасны дагуу хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэрийн тал хувь нь буюу жилд дунджаар 16000 шийдвэр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаар дамжуулан биелэгдсэн байх бол үлдсэн тал хувь /ойролцоогоор 49%/ нь тухайн жилдээ биелэгдэлгүй үлддэг байна.

2012 онд батлагдсан Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулиар Шүүгчид олгогдсон бүрэн эрх, түүний хамгаалалттай холбоотой асуудлыг шинээр баталсан. Уг хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсгийн 9.2.10-т **“шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн статистик мэдээлэлд хяналт тавьж, холбогдох байгууллагад шаардлага тавих”** бүрэн эрхийг шүүгчид олгосон. Хууль хүчин төгөлдөр хэрэгжих хугацаанд шүүгчээс өөрийн шийдвэрийн биелэлтэд хяналт тавьсан тохиолдол гараагүй байна. Энэ нь шүүгчээс дээрх бүрэн эрхийг хэрхэн хэрэгжүүлэх механизмын талаар уг хууль болон бусад хуулиар тодорхой зохицуулаагүйтэй холбоотой.

Мөн шүүхийн шийдвэрийг заавал биелүүлэх, түүнийг биелүүлээгүй тохиолдолд албадан биелүүлэх талаар хуульд тусгасан боловч шүүхийн шийдвэрийг санаатайгаар биелүүлээгүй, зайлсхийсэн тохиолдолд ямар хариуцлага хүлээлгэх талаар анхаарах, зохицуулалтгүй үлдсэн гэж болохоор асуудал байна. Мөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны мэдээнээс үзвэл хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэрийн тал хувь нь л шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаар дамжин биелэгдэж байгаа нь шүүхийн шийдвэрийг заавал биелүүлэх зарчим алдагдаж буй хэрэг юм. Ийнхүү шүүхийн шийдвэрийг сайн дураараа заавал биелүүлэх зарчмыг зөрчсөн тохиолдолд хувь хүн, хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэх ёстой. Зөрчлийн хууль болон эрүүгийн хуульд “шүүхийн шийдвэрийг үл биелүүлэх, санаатайгаар зайлсхийх тухай” зөрчил, гэмт хэргийг заасан байх боловч дээрх хуулийн заалтад шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй арга, үйлдэл, зорилгыг тоочсон байх нь зарим санаатай үйлдэл, аргыг орхигдуулах, гэмт хэрэг зөрчилд тооцох боломжгүй болгох эрсдэлтэй байна.

Энэ нь иргэн, аж ахуй нэгжийн зөрчигдсөн эрхийг сэргээх, тэдгээрийн эрх, ашгийг хамгаалах боломжийг хязгаарлаж буй хэрэг юм. Иймээс дээрх тодорхойгүй, орхигдуулсан хэм хэмжээг хэрэгжүүлэх зохицуулалтыг нэмэх, шүүхийн шийдвэрийг биелүүлэхээс санаатай зайлсхийж байгаа тохиолдолд хүлээлгэх хариуцлагын зохицуулалтыг мөн боловсронгуй болгох шаардлагатай байна.

--oOo--



## Ашигласан эх сурвалж

1. Монгол Улсын Шүүхийн тухай хууль, 2012
2. Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль, 2012
3. Зөрчлийн тухай хууль, 2017
4. Эрүүгийн хууль, 2002
5. Эрүүгийн хууль/шинэчилсэн найруулга/, 2017
6. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, 2017
7. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2002
8. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 2016
9. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2017
10. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, 2017
11. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны 2014-2016 оны гүйцэтгэх баримт бичгийн мэдээ.
12. Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн, Монгол Улсын шүүхийн шүүн таслах ажиллагааны эрүүгийн хэргийн статистик мэдээ.
13. Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллага “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг боловсронгуй болгох-чадавхийг бэх үүлэх” төсөл. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа гарын авлага. УБ.,2016
14. Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллага “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг боловсронгуй болгох-чадавхийг бэхжүүлэх” төсөл. Хөдлөх, үл хөдлөх эд хөрөнгө, шаардах эрхээс төлбөр гаргуулах ажиллагаа гарын авлага. УБ.,2015 он

